

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2025.12.25

Улаанбаатар хот

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1 Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт дүүрэг хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт;

Дүүргийн хэмжээнд нэгдүгээр улиралд 50 тогтоол, шийдвэрийн 91 заалт 73 хувьтай хэрэгжих шатанд байсан хагас жилийн байдлаар 34 тогтоол, шийдвэрийн 63 заалт 65 хувь, 3 дугаар улиралд 85 хувь, жилийн эцэст 52 тогтоол, шийдвэрийн 97 заалт 91,4% хэрэгжсэн бөгөөд тухай бүр хяналт шинжилгээ хийн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь илгээн тайлагнасан.

**ДҮҮРЭГТ ХЭРЭГЖИЖ БУЙ ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО**

№	Үзүүлэлт	Улсын их хурлын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж	Ерөнхий сайдын албан даалгаар	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгаар	НИТХ-ын тогтоол	Нийслэлийн Засаг даргын захирамж	НЗД-ын зөвлөлийн хурлын албан даалгаар	ДИТХ-ын тогтоол	Нийт
1	Хяналтад авсан тогтоол, шийдвэрийн нийт тоо	1	2	1	3	18	3	1	2	6	6	9	52
2	Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	1	4	1	17	27	3	2	2	6	13	21	97
3	Бүрэн хэрэгжсэн 90-100%		4		17	11	3	2	2	6	12	17	74
4	Хэрэгжих шатанд 50-90%	1		1		10					1	3	16
5	Хэрэгжилт хангалтгүй 10- 50%					5						1	6
6	Хэрэгжээгүй 0-10%					1							1
8	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй												0
9	Хяналтаас хасуулах												0
БИЕЛЭЛТИЙН ДҮН (хувь)		100%	100%	50%	98,4%	72%	100%	100%	100%	100%	96,9%	88,4%	91,4%

1.2 Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийслэлийн удирдах ажилтнуудын 22 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн дүүрэгт хамаарах нийт 106 үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тухай бүр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт цахимаар тайлагнасан. Тайлант хугацаанд өгөгдсөн 106 үүрэг даалгавар дунджаар 89,1%, хэрэгжсэн байна.

Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 21 удаа зохион байгуулж, 134 үүрэг даалгаврыг холбогдох хэлтэс албадад хүргүүлэн, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх 25 хэлтэс албадаас үүрэг даалгаврын биелэлт болон 14 хоногийн нөхцөл байдлын мэдээг авч нэгтгэн тухай бүр шуурхай зөвлөгөөнд танилцуулж ажилласан. Тайлант хугацаанд өгөгдсөн 134 үүрэг даалгавар дунджаар 80% хэрэгжсэн байна.



1.3 Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;

Дүүргийн Засаг даргын 2025 оны хариуцлагын гэрээний 2 бүлэг 10 зорилт, 109 арга хэмжээ хагас жилийн байдлаар 53,8% үр дүн хангалтгүй байсан бол жилийн эцэст 91,1% үр дүнтэй хэрэгжсэн.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН 2025 ОНЫ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

№	Зорилт, арга хэмжээ	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй 85%-аас дээш	Үр дүн хүлээгдэж байгаа 60-84	Үр дүн хангалтгүй 30-59	Үр дүн гараагүй 0-29	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Үнэлгээ (хувь)
	Бүлэг								
1	Дүүргийн Засаг даргын эрх, үүрэг	9	104	97	3	4			96,0%
2	Нийслэлийн Засаг даргын дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт	1	5	3	1	1			86,3%
	НИЙТ ДҮН	10	109	100	4	5			91,1%

1.4 “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд дүүрэг хамтран хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөөнөөс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 2 бүлгийн 3 арга хэмжээ хагас жилийн байдлаар 63,3%, жилийн эцэст 97,5%-үр дүнтэй хэрэгжлээ.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧОО**

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (85+)	Үр дүн хүлээгдэж байгаа (60-84)	Үр дүн хангалтгүй (30-59)	Үр дүн гараагүй (0-29)	Биелэлт (хувь)
Нэг. Бүсчилсэн хөгжлийн бодлого	1	1	2	-	-	2	-	85%
Дөрөв. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	1	1	1	1	-	-	-	100%
Нийт	2	2	3	1	-	2	-	97,5%

Таван жилийн үндсэн чиглэлийн 1 бүлэг, 2 зорилт, 4 арга хэмжээ жилийн эцэст 100%, хяналт шинжилгээ, үнэлгээний 1 арга хэмжээ 100%-үр дүнтэй хэрэгжсэн.

**МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛЭЭС ХАН-УУЛ ДҮҮРЭГ
ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОВЧОО**

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (100)	Тодорхой үр дүнд хүрсэн (70-100)	Эрчимжүүлэх шаардлагатай (30-70)	Үр дүнгүй (0-30)	Биелэлт (хувь)	Шалгуур үзүүлэлтэд тусгасан арга хэмжээ	Үнэлгээ /хувь/
Ес. Улаанбаатар ба дагуул хот	1	2	4	1	3	-	-	100%	1	100%

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1 арга хэмжээ жилийн эцсийн байдлаар 100% үр дүнтэй хэрэгжиж, Засгийн газрын бодлогын баримт бичгийн тайлангуудыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний 04/1816 дугаар албан бичгээр 62 хуудас нотлох баримтын хамт нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэн рүү цахимаар илгээж, тайлагнасан.

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ХАН-УУЛ ДҮҮРЭГ
ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй /85+/	Үр дүн хүлээгдэж байгаа /60-84/	Үр дүн хангалтгүй /30-59/	Үр дүн гараагүй /0-29/	Биелэлт /хувь/
Хоёр. Бүсчилсэн хөгжлийн бодлого	1	1	1	1	-	-	-	100%

1.5 "Нийслэлийн Засаг даргын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөөнөөс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 4 бүлэг, 6 зорилго 14 зорилт, 23 арга хэмжээ

хагас жилийн байдлаар 70%, жилийн эцэст 96%, Хяналт шинжилгээний 3 бүлгийн 17 шалгуур үзүүлэлт 93,8% үр дүнтэй хэрэгжжээ.

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧОО**

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (85%+)	Үр дүн хүлээгдэж байгаа (60-84)	Үр дүн хангалтгүй (30-59)	Үр дүн гараагүй (0-29)	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Биелэлт (хувь)
Нэг. Бүсчилсэн хөгжлийн бодлого	2	5	8	2	1	-	-	1	93%
Хоёр. Хүний хөгжлийн бодлого	2	7	13	-	-	1	-	1	96,3%
Дөрөв. Ногоон хөгжлийн бодлого	1	1	1	-	-	-	-	-	100%
Тав. Засаглалын бодлого	1	1	1	1	-	-	-	-	100%

Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 3 арга хэмжээ хагас жилийн байдлаар 78,3% хэрэгжиж үр дүн хүлээгдэж байсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 100% үр дүнтэй хэрэгжжээ.

**НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (85+)	Үр дүн хүлээгдэж байгаа (60-84)	Үр дүн хангалтгүй (30-59)	Үр дүн гараагүй (0-29)	Биелэлт (хувь)	Шалгуур үзүүлэлтэд тусгасан арга хэмжээ	Үнэлгээ (хувь)
Ес. Улаанбаатар ба дагуул хот	3	3	3	1	3	-	-	100%	3	100%

Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнөөс Хан-Уул хамтран 4 бүлэг, 6 зорилго, 14 зорилтын хүрээнд 23 арга хэмжээ хагас жилийн байдлаар 54% үр дүн хангалтгүй байсан бол жилийн эцэст 91%, 3 бүлгийн 17 шалгуур үзүүлэлт 100%-үр дүнтэй хэрэгжсэн. Нийслэлийн бодлогын баримт бичгийн тайлангуудыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний 04/1816 дугаар албан бичгээр 53 хуудас нотлох баримтын хамт нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнд хугацаанд цахимаар илгээж, тайлагнасан.

**НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ХАН-УУЛ ДҮҮРЭГ ХАМТРАН
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Үр дүнтэй (85%+)	Үр дүн хүлээгдэж байгаа (60-84)	Үр дүн хангалтгүй (30-59)	Үр дүн гараагүй (0-29)	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Биелэлт (хувь)
Нэг. Бүсчилсэн хөгжлийн бодлого	2	5	8	2	1	-	-	1	93%
Хоёр. Хүний хөгжлийн бодлого	2	7	13	-	-	1	-	1	96,3%
Дөрөв. Ногоон хөгжлийн бодлого	1	1	1	-	-	-	-	-	100%
Тав. Засаглалын бодлого	1	1	1	1	-	-	-	-	100%

1.6 Дүүргийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3 бүлэг, 15 зорилго, 90 зорилтын хүрээнд 136 арга хэмжээ 90,8%, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 94 шалгуур үзүүлэлт 88,2% үр дүнтэй хэрэгжсэн. Биелэлтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, 2025 оны 15 тогтоолоор "Хангалттай" үнэлэгдсэн.

№	Агуулга	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Бүрэн хангалттай (85буюу түүнээс дээш)	Хангалттай (70-85 хүртэл)	Хангалтгүй (70 хүртэл)	Хугацаа болоогүй	Биелэлт
1	Төрийн албаны зохион байгуулалт- 20 минутын хотын шилжилт	3	20	38	32	3	3		92.6%
2	Эко дүүрэг-Ногоон хөгжил	9	54	78	57	7	11	3	88.1%
3	Дэд бүтэц-Хот нийтийн аж ахуй	3	16	20	15	2	2	1	91.6%
НИЙТ ДҮН		15	90	136	104	12	16	4	90.8%


1.7 Засаг даргын Тамгын газрын 2025 оны хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ;

Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн тайлангийн 15 зорилго, 61 зорилт, 122 арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 71,2%, "Хангалттай" хэрэгжилттэй байсан бөгөөд жилийн эцэст 93,3% "Бүрэн хангалттай"


хэрэгжсэн бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний илтгэх хуудсын хамт нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 6, 12 дугаар саруудад заасан хугацаанд 04/959, 04/1829 дугаар албан бичгээр болон цахимаар илгээж, тайлагнасан.

Бүлэг	Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Бүрэн хангалттай (85 буюу түүнээс дээш)	Хангалттай (70-85 хүртэл)	Хангалтгүй (70 хүртэл)	Хугацаа болоогүй	Үнэлгээ (хувь)
Төрийн албаны зохион байгуулалт-20 минутын хотын шилжилт	3	16	33	29	4			95.8%
Эко дүүрэг-Ногоон хөгжил	9	31	53	41	5	6	1	91.3%
Дэд бүтэц-Хот нийтийн аж ахуй	3	13	14	10	1	3		85.6%
Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд	1	1	22	22				99.3%
НИЙТ ДҮН	16	61	122	102	10	9	1	93.3%

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН



ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮР ДҮН

2.1 Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн санал, зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал;



Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газар болон нийслэлийн Засаг даргын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2025 оны төлөвлөгөөнөөс тус дүүрэг хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 4.4.6, 4.4.7, 5.3, 5.4, 5.5-д заасны дагуу хийсэн хяналт шинжилгээ хийж, холбогдох нотлох баримтын хамт хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 115 хуудастай



Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 03/6117 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улс, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2025 оны төлөвлөгөөнөөс тус дүүрэг хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 4.4.6, 4.4.7, 5.3, 5.4, 5.5-д заасны дагуу хийсэн хяналт шинжилгээ хийж, холбогдох нотлох баримтын хамт 2012 оны

12 дугаар сарын 01-ний 04/1816 дугаар албан бичгээр нийслэлийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт илгээж, тайлагнасан.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг тус тус танилцуулах сургалтыг хүрээнд 2025 оны 05, 08 дугаар сард Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх 30 байгууллага, хороодын 25 албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Сургалтын үеэр дэргэдэх байгууллагын үйл ажиллагааны явц, гүйцэтгэлийг үнэлэх “Хяналт-шинжилгээ, үнэлгээний программ”-ыг танилцуулж, мэдээлэл өгсөн.



Дүүргийн засаг захиргааны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагааны хагас жилийн гүйцэтгэлд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, тайланг удирдлагад танилцуулсан.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмжийг Засаг даргын Тамгын газрын 2025 оны 04/1350 дугаар албан бичгээр дэргэдэх 30 байгууллагад хүргүүлсэн.



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Иргэдэд үйлчлэх төв байр,
Чингисийн өргөн чөлөө, 20 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17042
Утас/Факс: (976-11) 7777 1965
Цахим шуудан: info@khanuul.mn
Цахим хуудас: www.khanuul.mn

“ХАН-УУЛ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ХОРООНД

2025.09.11 № 04-1350
тантай _____ -ны № _____ -д

Зөвлөмж хүргүүлэх тухай

Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх байгууллагуудын 2025 оны хагас жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг хавсралтаар хүргүүлэв.

Зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн биелэлтийг 11 дүгээр сарын 28-ны дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ үү.

Хавсралт 2 хуудастай.



Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Заяабаатар Буянт
2025.09.11 15:40

2.3 Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал;


Тайлант хугацаанд 1 өргөдөл, 246 албан бичиг ирүүлснийг судлан хугацаатай хариутай 36 албан бичиг, 1 өргөдлийн хариуг хугацаанд нь хүргүүлж, зөрчилгүй, бүрэн шийдвэрлэсэн.

Байгууллагын 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн байнга хадгалах 10, түр хадгалах 1, нийт 11 хадгаламжийн нэгжийн 1968 хуудас бүхий баримтыг холбогдох стандартын дагуу цахим архивын хамт бүрдүүлж, Засаг даргын Тамгын газрын архивт 2025 оны 03 дугаар сарын 06-нд акт үйлдэж хүлээлгэн өгсөн.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ч.МӨНХГЭРЭЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
ХАРИУЦСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
МЭРГЭЖИЛТЭН  Н.АЛДАРМАА